

ХОВД АЙМАГ БОЛОН МОЭНКО ХХК ХООРОНДЫН ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

Энэхүү гэрээг Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалтыг удирдлага болгон /цаашид “гэрээ” гэх/ нэг талаас Ховд аймаг, түүнийг төлөөлж тус аймгийн Засаг дарга М.Амарсанаа (цаашид “Ховд аймаг” гэх), нөгөө талаас МоЭнКо ХХК, түүнийг төлөөлж Дэд захирал Ж.Оюунчимэг нар (цаашид “Компани” гэх), (хамтад нь “Талууд” гэх) 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдөр байгуулав.

ТАЛУУД ЭНЭХҮҮ ГЭРЭЭГ БАЙГУУЛАХДАА:

МоЭнКо ХХК нь Ховд аймгийн Дарви сумын нутагт орших Хөшөөтийн нүүрсний ордод ашигт малтмалын ашиглалтын Тусгай зөвшөөрөл эзэмшигч бөгөөд Хөшөөт төслийн (Төсөл) Хөрөнгө оруулагч болохыг дурьдаж;

Талууд нь Төслийг амжилттай хэрэгжүүлэхэд бүх талын хүчин чармайлт гаргаж, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, уул уурхайн үйл ажиллагааг байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл багатайгаар явуулах, байгаль орчныг нөхөн сэргээх, Төслийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг үе шаттай хэрэгжүүлж, Ховд аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулж, орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлэх, бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр ил тод, үр ашигтай хамтран ажиллах хүсэл эрмэлзлэлтэй байгааг тэмдэглэн;

Дараахь нөхцөлөөр харилцан тохирч байгуулав.

1. Нийтлэг үндэслэл

1.1 Энэ гэрээ нь нэг талаас төслийн хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, нөгөө талаас хариуцлагатай уул уурхайг эрхэлж, орон нутгийн хөгжлийг дэмжих үндсэн зорилтыг хэрэгжүүлэхтэй холбоотой Талууд хоорондын харилцааг зохицуулна.

1.2 Энэ гэрээгээр зохицуулаагүй харилцааг Монгол улсын холбогдох хууль тогтоомж, олон улсын гэрээнд заасны дагуу зохицуулна.


2. Нэр, томъёоны тодорхойлолт

Гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурьдсан агуулгаар ойлгоно:

2.1 “Гэрээт талбай” гэж энэхүү гэрээний 6.1-д тодорхойлсон талбайг;

2.2 “Төсөл” гэж хууль тогтоомжийн дагуу олгогдсон тусгай зөвшөөрлийн дагуу МоЭнКо ХХК-иас Хөшөөтийн уурхайд ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаа явуулахтай холбоотой үйл ажиллагаа, бүтээн байгуулалтыг;

2.3 “Уурхайн дэд бүтэц” гэж Хөшөөт Ярант чиглэлийн 311 км хатуу хучилттай зам, гүүрийн байгууламж, Булган боомт дахь нүүрсний тусгай гарц бүхий талбай, уурхайн дотоодын зам, талбай, суваг, хоолой, эрчим хүчний барилга



байгууламж, харилцаа холбоо, ус, дулаан хангамжийн шугам, нүүрс баяжуулах үйлдвэр, Хөшөөт болон Үенч суман дахь гаалийн хяналтын талбай, уурхайн кемп, оффис, спорт зал, нүүрс химийн лаборатори, засварын цех, гараж, тоосжилтоос хамгаалах хашаа, үйлдвэрлэлийн зориулалт бүхий бусад барилга байгууламжийг;

2.4 “Үндсэн үйл ажиллагаа” гэж энэхүү гэрээний 9.1-д тодорхойлсон үйл ажиллагааг;

2.5 “Туслан гүйцэтгэгч” гэж Төслийн үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд гэрээгээр ажил, үйлчилгээ үзүүлж буй аж ахуйн нэгжийг;

2.6 “Нөлөөллийн сум” гэж Төслийн үйл ажиллагааны шууд нөлөөлөлд өртөж буй Дарви, Цэцэг, Үенч, Булган, Алтай сумдыг;

2.7 “Хамтын ажиллагааны хороо” (“Хороо” гэх) гэж гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах үүрэг бүхий энэ гэрээний 25.1-д заасан бүтцийг;

2.8 “Орон нутгийн аж ахуйн нэгж” гэж Ховд аймгийн Улсын бүртгэлийн болон Татварын хэлтэст бүртгэлтэй аж ахуйн нэгжийг;

2.9 “Гуравдагч этгээд” гэж энэ гэрээний талуудаас бусад эрх ашиг, сонирхол нь хөндөгдсөн иргэн, хуулийн этгээдийг,

2.10 “Экспортлосон нүүрс” гэж Хөшөөтийн уурхайгаас улсын хилээр нэвтэрч, БНХАУ-д экспортолсон нүүрс гэж ойлгоно.

2.11 “Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага” гэж соёл, урлаг, боловсрол, хүмүүжил, шинжлэх ухаан, эрүүл мэнд, спорт, байгаль орчин, орчин ахуйн хөгжил, хүний эрх, хүн амын тодорхой бүлэг, давхаргын эрх ашгийг хамгаалах, энэрлийн зэрэг чиглэлээр нийгмийн тусын тулд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа явуулах зорилго бүхий байгууллагыг;

3. Хамтын ажиллагааны зарчим

Талуудын хамтын ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

3.1 Мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангаж, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх

3.2 Гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх

3.3 Талуудын тэгш, шударга оролцоог хангах, үл ялгаварлах

3.4 Нийгмийн түншлэлийг хөгжүүлэх

3.5 Харилцан бие биеийнхээ хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэж, хуулийг дээдлэх

4. Талуудын харилцаа

4.1 Ховд аймгийн хөгжлийн бодлогын нэгдмэл байдлыг хангах зорилгоор Талууд хоорондын хамтын ажиллагааг энэ гэрээгээр, энэ гэрээгээр



зохицуулагдаагүй харилцааг Монгол улсын хууль тогтоомж, олон улсын гэрээгээр зохицуулна.

4.2 Ховд аймаг нь Төслийн нөлөөллийн сумдын төлөөллийг гэрээ байгуулах, хэрэгжилтэнд хяналт тавих, дүгнэх хамтарсан ажлын хэсэгт болон Хамтын ажиллагааны хороонд оролцуулна.

4.3 Талууд энэхүү гэрээг Монгол улсын Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолоор баталсан орон нутагтай хамтран ажиллах загвар гэрээний агуулгад нийцүүлэн байгуулж, Ховд аймгийг төлөөлж аймгийн Засаг дарга, Дарви сумын Засаг дарга болон компанийн төлөөлөл гэрээг баталгаажуулан гарын үсэг зурна.

4.4 Компани орон нутгийн төр захиргааны болон олон нийтийн байгууллагуудтай энэ гэрээ болон хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллана.

5. Гэрээний хугацаа

5.1 Энэ гэрээг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхлэх бөгөөд 2028 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл 4 жилийн хугацаанд үргэлжлэн хэрэгжинэ.

5.2 Талууд гэрээний хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө гэрээг цаашид шинэчлэн байгуулах асуудлаар хэлэлцэн тохирно.

6. Гэрээт талбай

6.1 Ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаа явуулахтай нь холбогдуулан МоЭнКо ХХК-д эрх бүхий байгууллагаас олгосон дараахь талбай нь гэрээт талбайд хамаарна.

6.1.1 Ашигт малтмалын газраас Ховд аймгийн Дарви сумын нутагт орших Хөшөөтийн орд газарт ашигт малтмал ашиглах зориулалтаар олгосон MV-001640, MV-004322, MV-006525, MV-011887, MV-011888, MV-015289, MV-020299, MV-001414 тоот тусгай зөвшөөрөл бүхий, энэхүү гэрээний хавсралт 1-д заасан координат бүхий талбай;

6.1.2 Дарви сумын Засаг даргын 2010 оны 73, 2022 оны А/231 тоот захирамжаар үйлдвэрлэлийн болон хөрсний овоолгын зориулалтаар олгосон 0005373 тоот газар ашиглах гэрчилгээ бүхий талбай;

6.1.3 Үенч сумын Засаг даргын 2017 оны А/59, 2022 оны А/59 тоот захирамжаар Гаалийн хяналтын бүсийн зориулалтаар олгосон 0003445011 тоот газар ашиглах гэрчилгээ бүхий талбай;

6.2 Ховд аймаг болон тухайн сумдын зүгээс гэрээт талбайд гуравдагч этгээдэд аливаа зориулалтаар давхардуулан газар олгохгүй. Хэрэв Газрын тухай хууль болон энэ гэрээг зөрчиж, гэрээт талбайд давхардуулан газар олгосон бол Аймаг уг шийдвэрийг хүчингүй болгож, гэрээг зөрчсөнөөс үүдэн гарах үр дагаврыг бүрэн хариуцна.



7. Компанийн нийтлэг эрх, үүрэг

Компани дараахь нийтлэг эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

7.1 Тусгай зөвшөөрөл бүхий талбайгаас ашигт малтмал хайх, олборлох, түүний ашигт агуулгыг нэмэгдүүлэх, баяжуулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, тээвэрлэх, борлуулах болон эдгээртэй холбоотой бусад үйл ажиллагааг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэх;

7.2 Үйлдвэрлэлийн шаардлагатай дэд бүтэц, барилга байгууламж барих, ашиглах;

7.3 Үндсэн үйл ажиллагааг хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар явуулах;

7.4 Орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах, төслийн бараа бүтээгдэхүүний ханган нийлүүлэлт, үйлдвэрлэл, үйлчилгээг энэ гэрээнд заасан нөхцөлөөр орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүдээр гүйцэтгүүлэх;

7.5 Орон нутгийн төр, захиргааны байгууллагаас Төслийн дэд бүтцийг өргөтгөх, үйл ажиллагааг тасралтгүй явуулахад шаардагдах зөвшөөрөл, бусад дэмжлэг туслалцаа авах;

7.6 Нийгмийн хариуцлагын хүрээнд зорилтот бүлэг рүү хандсан дэмжлэг, туслалцааг сайн дурын үндсэн дээр үзүүлэх;

7.7 Төслийн хэрэгжилт, үйл ажиллагааны талаар олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажлыг орон нутгийн засаг захиргаа, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, үйл ажиллагааны талаарх танилцуулга тайланг бүтэн жилээр Аймагт хүргүүлэх;

7.8 Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын тайланг иргэд, олон нийтэд жилд нэг удаа мэдээлэх;

7.9 Туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулахдаа холбогдох хууль тогтоомжоос гадна энэ гэрээг үндэслэл болгох;

7.10 Гэрээт талбайгаас олдсон археологи, антрапологийн ач холбогдол бүхий түүхийн үнэт олдвор, эд өлгийн зүйлс, соёлын үнэ цэнэтэй зүйлс олдсон тохиолдолд холбогдох газарт нэн даруй мэдэгдэж хуулийн дагуу шийдвэрлэх;

7.11 Байгаль орчныг хамгаалах, ажлын байр нэмэгдүүлэх, орон нутгийн хөгжил, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, соёл, спорт, дэд бүтэц, жижиг дунд үйлдвэрлэл, инноваци, аялал жуулчлал, мал аж ахуй, газар тариалангийн салбарыг дэмжих чиглэлээр төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Ховд аймгийн орон нутгийн хөгжлийн сан болон ТББ-н дансанд энэ гэрээнд заасан нөхцөлөөр мөнгөн хөрөнгө төвлөрүүлж, хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих;

7.12 Орон нутгийн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын дотоодын нүүрсний хэрэгцээг хангах ажлыг Ховд аймагтай хамтран зохион байгуулах;

7.13 Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн



тухай хуульд заасан ажил олгогчийн эрх үүргээ бүрэн хэрэгжүүлж, ажилтнуудын эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

7.14 Компани Дарви сумаас уурхайд ажиллаж буй өөрийн ажилтнуудыг уурхайн кемпэд байрлуулж, 14 хоногийн давтамжтайгаар нэгдсэн унаагаар тээвэрлэх;

7.15 Нүүрс тээврийн 311 км авто зам дагуу хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Булган, Цэцэг сумын цагдаагийн тасагт дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах хүрээнд тус зам дээр эргүүл пост хийх түлшний болон урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх, Цэцэг сумын Хажинга багийн нутагт байрлах Шар кемпийн баруун талын зорчих хэсгийн дагуу Тефис майнинг ХХК-тай хамтарч зам чөлөөлөх талбай гаргах.

8. Ховд аймгийн нийтлэг эрх, үүрэг

Ховд аймаг дараахь нийтлэг эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

8.1 Төслийн үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулахад шаардлагатай дэмжлэг үзүүлж, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх;

8.2 Иргэд, олон нийтэд төслийн үйл ажиллагааны талаарх үнэн зөв, бодит мэдээлийг тогтмол хүргэж, бодит бус мэдээллийг залруулах арга хэмжээ авах;

8.3 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг байгаль орчны үнэлгээ болон менежмент төлөвлөгөөний дагуу хийгдэж буй эсэхэд хяналт тавьж, хамтран ажиллах;

8.4 Үйлдвэр, уурхай, суурин түүний цахилгаан, дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ байгуулах, гэрээт талбайд нүүрсний нөөц нэмэгдүүлэх, овоолго хийх, нарийвчилсан хайгуул судалгаа хийх, барилга байгууламжийн болон уурхай, үйлдвэрлэлийн хэрэгцээнд шаардлагатай газар олголт, эрчим хүч, ус хангамж, мод тарих зэрэг шаардлагатай зөвшөөрлийг хуулийн хүрээнд саадгүй олгох;


8.5 Компанийн зүгээс тавьсан санал, хүсэлтийг шуурхай шийдвэрлэх, шаардлагатай бол төр захиргааны холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх арга хэмжээ авах;

8.6 Компаниас энэ гэрээнд заасны дагуу Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлсэн хандив, тусламжийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, хяналт тавих, хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүн, хэрэгжилтийн талаар Компани болон олон нийтэд ил тод мэдээлэх;

8.7 Орон нутгийн иргэдэд мэргэжил эзэмшүүлэх, ажлын байраар хангах асуудлыг талууд хамтран зохион байгуулах;

8.8 Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, Хамтын Ажиллагааны Хороог тогтвортой ажиллуулах;

8.9 Орон нутагт ижил үйл ажиллагаа явуулж буй тээврийн болон уул уурхайн компаниудад нэг зарчмаар, шударга, тэгш хандах, тэдгээрт тавих хяналт, шаардлагыг ижил байлгана. Хэрэв шударга бус байдал үүссэн гэж үзвэл компани



энэ гэрээний нөхцөл, гэрээгээр хүлээсэн үүрэгт зохих өөрчлөлт оруулахыг шаардах эрхтэй ба Аймгийн зүгээс уг шаардлагыг хүлээн аваагүй, эсхүл ялгавартай нөхцөл байдлыг арилгах арга хэмжээ аваагүй бол Компани гэрээний тодорхой үүргээ хэрэгжүүлэхээс татгалзах эрхтэй.

8.10 Ховд аймаг нь хилийн боомтын нэвтрэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, нүүрсний экспортын хэвийн, тасралтгүй ажиллагааг хангах, мөн нүүрсний ачилт болон хилээр нэвтрэх хэмжээг тогтвортой өсгөх чиглэлээр хоёр улсын холбогдох байгууллагууд, тэр дундаа хил, гааль, авто тээврийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, төслийн үйл ажиллагаанд бүхий л түвшинд дэмжлэг үзүүлнэ. Асуудлыг шуурхай шийдвэрлэх, уялдаа холбоог сайжруулах зорилгоор компанитай харилцах тусгайлан хариуцсан хүнийг томилж ажиллуулна.

8.11 Гэрээний хэрэгжилтийн явцад иргэний нийгмийн байгууллагуудад мэдээлэл өгч хамтарч ажиллана.

8.12 Компанийн зарласан ажлын байр болон, бараа, ажил үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг орон нутгийн иргэд, байгууллагад хүргэж, ил тод, нээлттэй хэлбэрээр сонгон шалгаруулалтанд оролцох боломжийг бүрдүүлэх;

8.13 Ховд аймаг нь Гэрээний 18.1-д заасан хөрөнгийг нийтийн эзэмшлийн зам талбай, цэцэрлэгт хүрээлэн барьж байгуулах, ашиглах, хамгаалах, тохижуулах, цэцэрлэгжүүлэх, нийтийн тээврийн хөгжил, дэд бүтэц, байгаль орчин, спорт, соёл урлаг, боловсрол, эрүүл мэндийн арга хэмжээнд зарцуулна.

9. Үндсэн үйл ажиллагаа

9.1 Энэхүү Гэрээ нь Гэрээт талбайд ашигт малтмал эрэх, хайх, газрын гадаргуу болон түүний хэвлийгээс ашигт малтмал олборлох, тээвэрлэх, эрчим хүч, усны болон бусад дэд бүтцийг барьж байгуулах, тэдгээрийг ашиглах, нүүрс боловсруулах (хуурай аргаар баяжуулах, угаах, бутлах, шигших гэх мэт) бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, байгаль орчны нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалалт хийх, хөрс, нүүрсний овоолго, хог, хаягдлын менежмент болон Төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой бүх шатны үйл ажиллагаанд хамаарна.

9.2 Үндсэн үйл ажиллагааг саадгүй явуулахад нутгийн захиргааны болон мэргэжлийн байгууллагуудын зүгээс шаардлагатай дэмжлэг тусалцааг үзүүлж, хуулийн хүрээнд хамтарч ажиллана.

10. Татвар хураамж

10.1 Компани нь улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татвар, төлбөр, хураамжийг хуулийн хугацаанд төлнө.

10.2 Ховд аймаг нь төлбөр хураамжийн хэмжээг үл ялгаварлах зарчмаар тогтооно. Төслийн үйл ажиллагааны хүрээнд Компани болон түүний туслан гүйцэтгэгчид ногдуулж буй төлбөр, хураамжийн хувь хэмжээ, шаардлага нь тухайн нутаг дэвсгэрт ижил төрлийн үйл ажиллагаа явуулж буй бусад аж ахуйн нэгжид ноогдуулж буй төлбөр, хураамжтай ижил хэмжээнд байна.

10.3 Үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах үүднээс Ховд аймаг нь татварын таатай орчныг бүрдүүлж, төслийг бүх талаар дэмжиж ажиллана. Төсвийн



тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал өөрийн эрх хэмжээний хүрээнд татвар, төлбөр, хураамжийн хэмжээг тогтоохдоо өмнөх нөхцөлийг дордуулахгүй байна.

11. Байгаль орчин, газрын харилцаа

11.1 Компани нь байгаль орчныг хамгаалахтай холбоотой дараах үүргийг хүлээнэ:

11.1.1 Байгаль орчныг хамгаалах талаар Ашигт малтмалын тухай хуулийн 35, 37 дугаар зүйлийн биелэлтийг хангаж ажиллах;

11.1.2 Байгаль орчныг хамгаалах менежмент төлөвлөгөө, биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, энэ тухай тайланг жил тутамд аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Байгаль орчны газарт хүргүүлэх;

11.1.3 Байгаль орчны нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлсон төлөвлөгөөний дагуу үйлдвэр, уурхайн орчин, замын маршрутын дагуу хөрс, ургамал, булаг шанд, гол горхи, ан амьтан, түүхийн дурсгалт газар/хиргисүүр, хөшөө, хадны зураг/ хамгаалах ажлыг зохион байгуулах;

11.1.4 Хөрсний бохирдлыг зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, үйл ажиллагааны нөлөөллөөр эвдэгдсэн талбайг цаашид нийтийн хэрэгцээний зориулалтаар ашиглаж болохуйц байдлаар нөхөн сэргээж, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг авах;

11.1.5 Уурхайг ашиглах хугацаанд усны нөөцийг зохистой ашиглах зорилгоор үйлдвэрлэлийн хэрэгцээндээ аль болох гадаргын болон уурхайн шүүрлийн, цас, борооны усыг хуримтлуулан ашиглах;

11.1.6 Уурхайн тоосжилтыг бууруулах шинэ технологи, сайн туршлагыг хэрэгжүүлэх;

11.1.7 Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд хүлээсэн үүргийн дагуу Ховд аймагт 150000 модыг тарьж ургуулж, 3 жилийн хугацаанд арчлан ойжуулах арга хэмжээг авч, холбогдох агентлагт хүлээлгэн өгнө.

11.2 Ховд аймаг байгаль орчин, газрын харилцааны чиглэлээр дараах үүрэг хүлээнэ:

11.2.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих;

11.2.2 Төслийн хэрэгцээнд газар, ус ашиглах болон бусад шаардлагатай зөвшөөрлийг хууль тогтоомжийн хүрээнд саадгүй олгох;

11.2.3 Малчдын өвөлжөө хаваржааг нь нүүлгэн шилжүүлсэн, нөхөн олговор олгосон болон гэрээгээр чөлөөлсөн газарт дахин газар олголт хийхгүй ба энэ заалт зөрчигдсөнөөс үүсэх үр дагаврыг дангаар хариуцах;

11.2.4 Нүүлгэн шилжүүлэлтэд хамрагдсан Хөшөөт багийн иргэдэд өмнө нь олгогдсон газар эзэмших гэрчилгээг хүчингүй болгож, нүүн шилжсэн байршилд шинээр гэрчилгээ олгох;



12. Малчдын нөхөн олговор

12.1 Уурхайн тоосжилтийн шууд нөлөөлөлд өртөж буй малчдын өвөлжөө, хаваржааны судалгааг Аймаг (сум), Компани, Төфис майнинг ХХК болон мэргэжлийн байгууллагын хамтарсан ажлын хэсэг шинэчлэн гаргаж, тоосжилтын нөлөөллийг их, дунд, бага гэсэн 3 зэрэглэлээр тогтооно. Нөхөн олговрын хэмжээг нөлөөллийн зэрэглэлээс хамааруулан 1-3 сая төгрөгийн хязгаарт багтаах ба 70 хувийг Хөшөөтийн уурхайд олборлолт явуулж буй хоёр компани тэнцүү хувааж, 30 хувийг аймаг хариуцан жилд нэг удаа тус тус олгоно.

12.2 Тоосжилтод ихээр өртөж буй малчин өрхийг Хамтарсан ажлын хэсэг нэн тэргүүнд нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ авна. Энэ тохиолдолд Хөшөөтийн уурхайд олборлолт явуулж буй хоёр компани өвөлжөө хаваржааны нөхөн төлбөрийг адил тэнцүү хуваан төлөх, Аймаг өвөлжөө, хаваржааны газрыг шинээр олгох үүрэгтэй бөгөөд газрын байршлыг сонгохдоо уурхайн нөлөөлөлд дахин өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлнэ. Шинээр олгосон газар нь уурхайн нөлөөлөлд дахин өртсөн тохиолдолд Компани хариуцлага хүлээхгүй.

12.3 Тоосжилтын нөхөн олговрыг нүүлгэн шилжүүлэлтэд хамрагдсан малчин өрхөд давхардуулж олгохгүй бөгөөд тухайн сумын Засаг дарга нь нөлөөлөлд өртөж буй малчин өрхийн тоог цаашид нэмэгдүүлэхгүй байна.

12.4 Уурхайн үйл ажиллагаа 3 сар буюу түүнээс дээш хугацаанд зогссон тохиолдолд нөхөн олговрын хэмжээг уурхай зогссон хугацаанд хувь тэнцүүлэн бууруулж тооцно. Компаниас хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд тоосжилтын нөлөөлөл буурсан бол нөхөн олговортой холбоотой энэ гэрээний заалтуудыг Талууд дахин хэлэлцэнэ.


13. Дэд бүтэц

13.1 Ховд аймаг нь Төслийн хөрөнгөөр баригдсан үйлдвэрлэлийн дэд бүтцийг Тусгай зөвшөөрөл эзэмшигч зориулалтын дагуу ашиглах боломжийг бүрдүүлж, эзэмшигч, хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаална.

13.2 Төслийг амжилттай хэрэгжүүлэх зорилгоор төвийн эрчим хүчний системд шинээр холбогдох, хүчин чадлыг нэмэгдүүлэх, энэ чиглэлээр эрх, зөвшөөрөл авах, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэдстанц, эрчим хүчний барилга байгууламж барихад Ховд аймаг дэмжлэг үзүүлнэ.

13.3 Компани Төслийн хоёр дахь шатны бүтээн байгуулалтын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэр, гаалийн хяналтын талбайг шинээр барьж ашиглалтанд оруулна.

13.4 Компани нь 2026 оноос эхлэн жил бүр Ховд аймгийн зүгээс санал болгосон тодорхой бүтээн байгуулалтын төслийг дэмжих зорилгоор 1,5 тэрбум хүртлэх төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлнэ. Санхүүжилтэнд хамрагдах бүтээн байгуулалтын төсөл нь аж ахуйн нэгжүүд хөрөнгө оруулалт хийхийг төрөөс дэмжих татварын хөнгөлөлтийн бодлогод нийцсэн, байгаль орчны хамгаалал, нийгэмд чиглэсэн болон боловсруулах үйлдвэр, бүсчилсэн хөгжлийн бүтээн байгуулалтад чиглэгдэх бөгөөд уг санхүүжилт нь энэ гэрээний 18.1-д заасан хандивт



хамаарахгүй.

13.5 Хэрэв Компани энэ гэрээний 13.4-т заасан санхүүжилтийг төвлөрүүлсний дараа тухайн жилийн ААНОАТ-ын жилийн эцсийн тайлангаар алдагдалтай гарсан тохиолдолд уг санхүүжилт нь татварын хөнгөлөлтөд хамрагдахгүй тул дараа онд төвлөрүүлэх мөнгөн дүнгээс чөлөөлөгдөнө. Тухайн жилд компани ашигтай ажилласан боловч төлбөл зохих орлогын албан татварын дүн 1.5 тэрбум төгрөгт хүрээгүй тохиолдолд компани төлвөл зохих татварын дүнтэй дүйцэх хэмжээний санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

13.6 Аймгийн зүгээс дээрх санхүүжилт нь татварын хөнгөлөлтөд хамрагдах шаардлагад нийцсэн баримтуудыг зохих ёсоор бүрдүүлэхэд хамтарч ажиллана.

14. Авто замын ашиглалт

14.1 Компани Хөшөөт-Ярант чиглэлийн 311 км хатуу хучилттай авто замын (цаашид "авто зам" гэх) хууль ёсны эзэмшигч бөгөөд уг замыг Төслийн үйл ажиллагаанд зориулан ашиглана. Төслийн үйл ажиллагаанд саад учруулахааргүй бол зорчигч тээврийн зорилгоор орон нутгийн иргэд, байгууллага замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж зорчино.

14.2 Компанийн зөвшөөрөлгүйгээр уг замыг бизнесийн зорилгоор ашиглахыг хориглох ба Ховд аймгийн зүгээс авто зам эзэмшигчийн эрхийг хуулийн хүрээнд хамгаалж, шаардлагатай дэмжлэг үзүүлнэ.

14.3 Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах асуудлыг хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд Ховд аймгийн Цагдаагийн газар, Авто тээврийн төв хамтран зохион байгуулна.

14.4 Компани нь авто замын ашиглалтын байнгын бэлэн байдал, авто замын засвар, арчлалтын ажлыг хариуцан гүйцэтгэнэ.

15. Төслийн ажиллах хүч

15.1 Компани төслийн ажиллах хүчний 70-аас доошгүй хувийг орон нутгийн иргэдээс бүрдүүлнэ.

15.2 Компани орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр Аймагтай хамтран ажиллаж, шаардлагатай ажлын байр болон түүнд тавигдах шаардлагыг ил тод, нээлттэй зарлана.

15.3 Ховд аймаг нь Төслийн шугамаар гадаадаас ажиллах хүч авах, тэдгээрийг ажиллуулах асуудлаар хуулийн хүрээнд дэмжлэг үзүүлнэ.

15.4 Орон нутгийн бус ажилтан, мэргэжилтэн урт хугацаагаар авч ажиллуулах тохиолдолд хуулийн дагуу тухайн ажилтныг холбогдох байгууллагад бүртгүүлнэ.

16. Бараа, ажил үйлчилгээний худалдан авалт

16.1 Төслийн хүрээнд тухайн жилд орон нутгаас худалдан авах бараа, ажил үйлчилгээний тоо хэмжээ, нэр төрөл, тавигдах шаардлагын талаарх мэдээллийг өмнөх оны 12 дугаар сард багтаан нээлттэй мэдээлэх;



16.2 Компани нь төсөлд бараа бүтээгдэхүүн нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх боломж бүхий орон нутгийн аж ахуйн нэгжүүдийг дэмжиж, цаашид төслөөс хамааралгүйгээр үйл ажиллагаагаа бие даан явуулах боломжийг нь нэмэгдүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

16.3 Талууд орон нутгийн аж ахуйн нэгжүүдийн бараа, ажил үйлчилгээний чанар, стандартыг сайжруулах, үйл ажиллагааны чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор зөвлөмж, техникийн туслалцаа үзүүлэх замаар жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр хамтарч ажиллана.

16.4 Төслийн хэрэгцээнд бараа, ажил үйлчилгээг худалдан авахад тавигдах шаардлагыг ижил нөхцөлөөр хангаж буй орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд давуу эрх олгоно.

16.5 Төслийн хэрэгцээнд шаардлагатай мах, сүү, хүнс, хүнсний ногоо, цэвэр ус, машин техникийн түрээс, ажлын хувцас, эрүүл мэнд, байгаль орчны үйлчилгээ болон орон нутгаас нийлүүлэх боломжтой бусад бараа, ажил үйлчилгээг худалдан авахдаа зохих чанар, үнэ, стандартын шаардлага хангасан нөхцөлд төслийн нийт бараа, ажил үйлчилгээний худалдан авалтын 60-аас доошгүй хувийг орон нутгийн аж ахуйн нэгжүүдээр гүйцэтгүүлэх замаар жижиг дунд бизнесийг дэмжиж ажиллана.

17. Экспортын нүүрс тээвэрлэлт

17.1 Компани нь экспортын нүүрс тээвэрлэлтийг улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлт гүйцэтгэхэд тавигдах шаардлагыг бүрэн хангасан, Ховд аймагт бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдээр гүйцэтгүүлнэ. Тээвэрлэлт хийх аж ахуйн нэгжүүдийг Ховд аймгийн "Авто тээврийн төв" ТӨҮГ-аас бүртгэлжүүлнэ.

17.2 Компани өөрийн охин компаниар тээвэрлэлт гүйцэтгүүлэхдээ бусад аж ахуйн нэгжүүдтэй адил хуваарилалтаар оролцох ба давуу эрх эдлэхгүй. Тээврийн компаниудын тээврийн хэрэгслэлийн тоог 2025 оны 1-р улирлын С зөвшөөрлийн тоогоор хязгаарлах ба уг тоо хэмжээг нэмэгдүүлэх тохиолдолд бүх компанид адил тоогоор нэмэгдүүлнэ.

17.3 Тээвэрлэлтийн гэрээний нөхцөл, тээвэрлэлтийн үнэ хөлсийг Авто тээврийн тухай хуульд заасны дагуу Компани болон тээвэрлэгч аж ахуйн нэгжүүд сайн дурын үндсэн дээр харилцан тохиролцож тогтоох бөгөөд гэрээний талуудын чөлөөт байдалд бусад этгээдийн зүгээс хууль бусаар нөлөөлөх, дарамт шахалт үзүүлэхийг хориглоно.

17.4 Гэрээт аж ахуйн нэгжүүдийн зүгээс гэрээний үнэ, бусад нөхцөлтэй холбогдуулан санал гаргасан тохиолдолд талууд харилцан хэлэлцэж 30 хоногийн дотор зөвшилцөлд хүрнэ. Энэ хугацаанд Ховд аймгийн зүгээс Төслийн болон тээвэрлэлтийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах арга хэмжээг авна.

17.5 Тээвэрлэгч аж ахуйн нэгжүүд нь өөрийн үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомж, төрийн эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм журам, стандарт шаардлагыг бүрэн хэрэгжүүлж, Төслийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангахын зэрэгцээ өөрийн тээвэрчид, ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангаж, тэдгээрийн ажиллаж, амрах таатай нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй. Үүнд энэ гэрээний Талууд болон жолооч тээвэрчдийн хууль ёсны эрх ашгийг төлөөлөн хамгаалах



байгууллагын зүгээс хяналт тавьж ажиллана.

17.6 Тээвэрлэлтийн тонн/км-ийн үнийг тогтоохдоо эрх бүхий байгууллагаас тогтоосон жишиг тарифыг үндэслэн Компанийн санхүүгийн чадвар, ачааны зэрэг, ажил үйлчилгээний онцлог, замын нөхцөл, ачаа тээврийн эрэлт хэрэгцээ, түлшний үнийн хэлбэлзэл, нүүрсний зах зээлийн үнийн бууралт зэрэг тээвэрлэлтийн зардалд нөлөөлөх бусад хүчин зүйлүүдийг харгалзан, тээвэрлэлтийн гэрээний талууд харилцан тохиролцож тогтооно.

17.7 Компани уурхай эзэмшигчийн хувьд тээврийн хэрэгслэлийн тоо хэмжээ хангалттай байгаа нөхцөлд С зөвшөөрлийн тоог нэмэгдүүлэхгүй.

18. Орон нутгийн хөгжлийг дэмжих

18.1 Компани Ховд аймгийн ОНХСанд экспортлосон нүүрсний тонн тутмаас мөнгөн хөрөнгө төвлөрүүлэх замаар орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд дэмжлэг үзүүлнэ. Үүнд, тухайн жилд экспортлосон нүүрсний тонн тутмаас гэрээний хугацаанд 1,0 ам. долларыг төвлөрүүлэх ба тухайн жилд 2 сая тонноос дээш экспортлосон нүүрсний тонн тутмаас 1,2 ам. долларыг төвлөрүүлнэ.

18.2 Энэ гэрээний 18.1-д заасан санхүүгийн дэмжлэгийн 80 хувийг хандив хэлбэрээр Орон нутгийн хөгжлийн санд, үүнээс 70 хувийг нь Ховд аймгийн Орон нутгийн хөгжлийн санд, үлдэх 30 хувийг (тус бүр 15 хувийг) Дарви, Цэцэг сумын Орон нутгийн хөгжлийн санд тус тус төвлөрүүлнэ.

18.3 Компани Ховд аймгийн соёл, урлаг, боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, спорт, байгаль орчин, орчин ахуйн хөгжил, хүний эрх, хүн амын тодорхой бүлэг, давхаргын эрх ашгийг хамгаалах, энэрлийн зэрэг чиглэлээр нийгмийн тусын тулд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа явуулах зорилго бүхий НҮТББ-ыг энэ гэрээнд талууд гарын үсэг зурснаас хойш 30 хоногийн дотор шинээр үүсгэн байгуулж, энэ гэрээний 18.1-д заасан тонн тутмаас төвлөрүүлэх мөнгөн дүнгийн 20 хувийг дээрх НҮТББ-ын дансанд төвлөрүүлнэ.

18.4 НҮТББ-ын дүрмийн хүрээнд Компани Ховд аймгийн төлөөллийг Удирдах Зөвлөлд томилуулна. Удирдах Зөвлөлөөс тус НҮТББ-ын гүйцэтгэх захирлыг сонгон, гэрээ байгуулж ажиллуулна.

18.5 Гүйцэтгэх захирал нь хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх төсөл арга хэмжээний талаар Аймгийн Засаг дарга, түүний зөвлөлөөс дэмжлэг авсан төсөл, арга хэмжээг Удирдах зөвлөлд танилцуулах бөгөөд Удирдах Зөвлөл нь НҮТББ-ийн дүрэм, үйл ажиллагааны зорилгод нийцсэн байдлыг харгалзан тухайн арга хэмжээг санхүүжүүлнэ.

18.6 "НҮТББ"-ын санхүүжилтээр хийгдэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд Удирдах Зөвлөл хяналт тавьж ажиллана. НҮТББ-ын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг Гүйцэтгэх удирдлага аймгийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд улирал бүр хүргүүлнэ.

18.7 Улирлаар тооцоо нийлэх үед гэрээний үнийг баримтлахгүй бөгөөд зах зээлийн үнийн индекс болох sxcoal.com албан ёсны цахим хуудас дахь коксжих нүүрсний үнийн индекс гэрээ хүчин төгөлдөр үйлчилж эхлэх үеийн үнийн индексээс 30 болон түүнээс дээш хувиар буурсан үед гэрээний 18.1-д заасан экспортлосон

нүүрсний тонн тутмаас төвлөрүүлэх мөнгөн дүнг 20 хувиар бууруулан тооцож төвлөрүүлнэ. Коксжих нүүрсний үнийн индекс 50 болон түүнээс дээш хувиар буурсан бол давагдашгүй хүчин зүйлд тооцож, компанийн төвлөрүүлэх мөнгөн хөрөнгийн дүн хүчингүй болох бөгөөд үүнийг талууд дахин хэлэлцэж тогтооно.

18.8 Давагдашгүй хүчин зүйлийн улмаас нүүрсний экспорт дараалсан 30 өдөр буюу түүнээс дээш хугацаанд зогссон тохиолдолд Компани нүүрсний экспорт сэргэсэн өдрөөс хойш 15 хоногийн хугацаанд экспортлосон нүүрсэнд ногдох тонн тутмаас төвлөрүүлэх хандиваас чөлөөлөгдөнө.

18.9 Давагдашгүй хүчин зүйлийн улмаас нүүрсний экспорт дараалсан 60 өдөр буюу түүнээс дээш хугацаанд зогссон тохиолдолд энэ гэрээний 18.1-д заасан тонн тутмаас төвлөрүүлэх хандив болон санхүүжилтийн тогтсон дүн хүчингүй болох бөгөөд Талууд гэрээний нөхцөлийг дахин хэлэлцэнэ.

18.10 Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэх хандив болон "НҮТББ" дансанд төвлөрүүлэх санхүүжилтийг Компани улирлаар тооцож олгох бөгөөд тухайн улирал дууссанаас хойш 20 хоногийн дотор холбогдох дансанд шилжүүлнэ. Сан тус бүрт шилжүүлэх мөнгөн хандив болон санхүүжилтийн дүн нь бодитоор экспортлосон нүүрсний тоо хэмжээнд үндэслэнэ. Экспортлосон нүүрсний хэмжээг гаалийн газрын мэдээнд тулгуурлах бөгөөд талууд сар бүрийн эцсээр тооцоо нийлж, баталгаажуулна.

18.11 Компани тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, бие даан хөгжих чадавхийг нь нэмэгдүүлэх, байгаль орчныг дүйцүүлэн хамгаалах чиглэлээр зорилтот төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

18.12 Компани үйл ажиллагааны тогтвортой байдал, санхүүгийн боломждоо тулгуурлан тухайн жилд хэрэгжүүлэх тогтвортой хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрийн чиглэлийг тодорхойлж, эхний хагас жилд багтаан төсөл сонгон шалгаруулах арга хэмжээг ил тод, нээлттэй хэлбэрээр зохион байгуулна.

18.13 Компани гэрээний хугацаанд дотоодын их дээд сургуульд тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр суралцаж буй 50 хүртэлх оюутанд сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэх ажлыг орон нутагтай хамтран хэрэгжүүлнэ.

18.14 Компани уг гэрээнд зааснаас бусдаар улс төрийн нам, төрийн байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн хандив, тусламжийн хүсэлтийг хүлээн авахгүй.

19. Орон нутгийн хэрэгцээний нүүрс

19.1 Орон нутгийн иргэд, байгууллагын хэрэгцээнд нүүрс нийлүүлэх ажлыг жил бүрийн 9 дүгээр сарын 1-нээс дараа жилийн 3 дугаар сарын 1-ний хооронд Аймагтай хамтран зохион байгуулна. Уг хугацаа нь Аймгийн дулааны станцыг нунтаг нүүрсээр хангахад хамааралгүй болно.

19.2 Ховд аймаг нь Хөшөөтийн уурхайг түшиглэн байгуулсан Шахмал түлшний үйлдвэр ашиглалтанд орсноор иргэд, байгууллагын хэрэгцээнд шахмал түлш нийлүүлнэ. Компани шахмал түлшний үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор, 150,000 тонн эрчим хүчний түүхий нүүрсийг үнэ төлбөргүй нийлүүлнэ. Цаашид нүүрс нийлүүлэх үнэ болон бусад нөхцөлийг тусад нь гэрээгээр тохиролцон тогтооно.



19.3 Тухайн жилд нийлүүлэх нүүрсний нийт хэмжээг өмнөх оны хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр Компани, Шахмал түлшний үйлдвэр болон Зүүн Хөшөөтийн уурхайн төлөөллөөс бүрдсэн Хамтарсан ажлын хэсгээр хэлэлцэн тохиролцоно. Нүүрс нийлүүлэх үйл ажиллагаанд талуудын тэгш оролцоог хангаж, гурван тал нүүрсний нийлүүлэлтийг тэнцүү хуваарилах зарчмаар тогтооно. Цаашид шахмал түлшний үйлдвэр ашиглалтанд орсноор орон нутгийн хэрэгцээний нүүрс нийлүүлэлтийг бүрэн хариуцна.

19.4 Компани гэрээний хугацаанд нэг тонн бүхэл нүүрсийг орон нутгийн иргэдэд 25000 төгрөгөөр, төрийн байгууллагад 60,000 төгрөгөөр, аж ахуйн нэгжид 65,000 төгрөгөөр, эрчим хүчний нунтаг нүүрсийг дулааны станц болон төвлөрсөн дулаанаар хангаж буй бусад байгууллагад 10,000 төгрөгөөр, аж ахуйн нэгжүүдэд 30,000 төгрөгөөр нийлүүлнэ. Аж ахуйн нэгжүүд нь нийлүүлэгдсэн нүүрсийг цааш дамжуулан худалдахгүйгээр зөвхөн өөрийн дотоод хэрэгцээнд ашиглана.

19.5 Ховд аймаг иргэд, байгууллагад бүхэл нүүрс түгээх ажлыг өөрийн цахим бүртгэлд үндэслэн ил тод, нээлттэй байдлаар зохион байгуулна.

19.6 Хэрэглэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд төлбөрөө цаг тухайд нь төлөөгүй бол Компани гэрээний дагуу нүүрс нийлүүлэхээс татгалзах эрхтэй.

20. Үйл ажиллагааны баталгаа

20.1 Хөрөнгө оруулагч, түүний хамааралтай этгээдийн Монгол Улсад оруулсан хөрөнгө оруулалт нь Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээгээр баталгаажсан эрх зүйн бүрэн хамгаалалтад байна.

20.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулах, хууль ёсны эрхээ хэрэгжүүлэхэд бусдын зүгээс саад учруулсан, эсхүл төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэр, үйл ажиллагааны улмаас Төслийн үйл ажиллагаа саатсан тохиолдолд Компани уг асуудлыг шийдвэрлүүлэхээр Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хандах бөгөөд Ховд аймаг хууль бус үйл ажиллагааг нэн даруй таслан зогсоох үүрэгтэй.

20.3 Хууль бус үйл ажиллагааг цаг тухайд нь таслан зогсоох арга хэмжээг зохих ёсоор аваагүйгээс Төслийн үйл ажиллагаа тухайн сард хуримтлагдсан 7 хоног буюу түүнээс дээш хугацаанд саатсан бол Компани тухайн сард төвлөрүүлэх хандивыг, хуримтлагдсан 14 хоног буюу түүнээс дээш хугацаанд саатсан бол тухайн улиралд ногдох хандивыг, хуримтлагдсан 30 хоног буюу түүнээс дээш хугацаанд саатсан бол тухайн жилд ногдох хандивыг төвлөрүүлэх үүрэг хүлээхгүй.

20.4 Төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэр, үйл ажиллагаанаас хамааран Төслийн үйл ажиллагаа, экспортын тээвэрлэлт саатсан бол Компани тухайн үйл явцыг баримтжуулж, саатсан хоног тутамд ногдох хандивыг тухайн улиралд төвлөрүүлвэл зохих хандиваас хасч тооцно.

20.5 Компани гуравдагч этгээдийн хууль бус үйл ажиллагааны улмаас өөрт учирсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээс гадна тодорхой хувь хүн, хуулийн этгээдийг Төслийн үйл ажиллагаанд аливаа хэлбэрээр оролцуулахгүй байх эрхтэй.

20.6 Энэ гэрээний 20.2-т заасан “хууль бус үйл ажиллагаа” гэдэгт иргэдийн



Үндсэн хуулиар олгогдсон жам ёсны эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой бөгөөд хуулийн дагуу эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан, компанийн хэвийн үйл ажиллагаанд үл нөлөөлөх тайван жагсаал, цуглаан хамаарахгүй.

21. Маргаан шийдвэрлэх

21.1 Талууд Гэрээнээс үүдэлтэй үл ойлголцол, маргааныг эвийн журмаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

21.2 Гэрээг хэрэгжүүлэх, талуудын хооронд үүссэн маргаантай асуудлыг шийдвэрлүүлэхээр гэрээний нэг тал нь нөгөө талдаа бичгээр мэдэгдэл хүргүүлнэ. Мэдэгдлийг хүлээн авснаас хойш Хамтын ажиллагааны Хороо уг асуудлыг ажлын 5 хоногт багтааж шийдвэрлэнэ.

21.3 Талууд тухайн асуудлаар 14 хоногийн хугацаанд шийдэлд хүрээгүй бол маргаж буй асуудлаар мэргэшсэн, хараат бус, хөндлөнгийн Зуучлагчийг санал нэгтгэйгээр томилно.

21.4 Гэрээний 21.3-т заасан Зуучлагч нь маргааныг 30 хоногийн дотор зохицуулж чадаагүй бол Талууд маргааныг арбитрийн шүүхээр шийдвэрлүүлнэ.

21.5 Гэрээний тодорхой заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой маргаан үүссэн нь Талууд гэрээний бусад заалтыг хэрэгжүүлэхгүй байх үндэслэл болохгүй.

22. Гэрээг зөрчсөнөөс үүсэх үр дагавар

22.1 Гэрээний аль нэг тал нь гэрээг зөрчсөн, гэрээний үүргээ биелүүлээгүйгээс нөгөө талд эдийн засгийн хувьд ноцтой хор уршиг, үр дагаврыг бий болгосон бол гэрээг цуцлах үндэслэл болно.

22.2 Энэ гэрээний 22.1-д дурьдсанаас бусад тохиолдолд Гэрээний нэг тал нь шаардлагатай бол гэрээний зөрчлийг арилгуулахаар нөгөө талдаа мэдэгдэл хүргүүлэх бөгөөд мэдэгдэл хүлээж авсан тал нь 14 хоногийн дотор зөрчлийг арилгах үүрэгтэй.

22.3 Зөрчлийн үр дагаврыг арилгах боломжгүй болсон бол гэрээг зөрчсөн тал цаашид гарах үр дагавраас сэргийлэх арга хэмжээг авч, нөгөө Талдаа бичгээр мэдэгдэнэ. Гэрээг зөрчсөн, гэрээний үүргээ биелүүлээгүйгээс учирсан хохирлыг эрх нь зөрчигдсөн тал нэхэмжлэх эрхтэй.

23. Давагдашгүй хүчин зүйл

23.1 Гэрээний аль нэг тал нь давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөр гэрээний үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон бол нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ. Ийнхүү мэдэгдэхдээ шалтгаан болон давагдашгүй хүчин зүйл арилах боломжит хугацааг мэдэгдэнэ.

23.2 Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөлөлд өртсөн талын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилт энэ тохиолдолд түдгэлзэх ба үүнээс үүдэлтэй үр дагавар, аливаа хохирол, төлбөр, хариуцлагаас бүрэн чөлөөлөгдөнө.

23.3 Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллийг талууд аль болох богино хугацаанд арилгахын тулд хамтран ажиллаж, шаардлагатай бүхий л арга хэмжээг

авна.

23.4 “Давагдашгүй хүчин зүйл” гэдэгт нөлөөлөлд өртсөн талын хүсэл зоригоос үл шалтгаалах дараах хүчин зүйлүүд хамаарна. Үүнд:

- 1) Дайн, үймээн самуун, бослого хөдөлгөөн, бүслэлт хориглолт
- 2) Хорио цээр, гал түймэр, газар хөдлөлт болон байгалийн гамшиг
- 3) Нүүрсний борлуулалтын зах зээлийн нөхцөл, үнэ ханшийн хэт бууралт, эдийн засгийн хямралт нөхцөл байдал нь Төслийн үйл ажиллагааг хэвийн явуулах боломжгүйд хүргэсэн бол
- 4) Төслийн үйл ажиллагааг саатуулах нөлөөлөл бүхий хоёр улсын төр, засгийн байгууллага, албан тушаалтны шийдвэр
- 5) Аль нэг талын буруугаас шууд шалтгаалаагүй техник, тоног төхөөрөмжийн томоохон эвдрэл сүйрэл

24. Хууль тогтоомж өөрчлөгдөх

24.1 Монгол улсын хууль тогтоомж болон олон улсын гэрээнд өөрчлөлт орсон нь энэ гэрээг хэрэгжүүлэх боломжгүйд хүргэсэн бол гэрээ бүхэлдээ хүчингүй болох бөгөөд харин тодорхой хэмжээнд сөргөөр нөлөөлөхөөр бол талууд тухайн асуудлыг хэлэлцэж, шаардлагатай бол гэрээнд өөрчлөлт оруулна.

25. Хамтын ажиллагааны хороо

25.1 Талуудын гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хамтын ажиллагааны хороо (цаашид "Хороо" гэх)-г Аймаг, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулна.

25.2 Хороо нь 9 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд талуудын оролцоог тэгш хангасан байна. Хорооны бүрэлдэхүүнд орох иргэдийн төлөөллийг Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас нэр дэвшүүлнэ. Хорооны бүрэлдэхүүнийг Ховд аймгийн Засаг дарга томилж, чөлөөлнө.

25.3 Хороо гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах ба гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой талуудын санал хүсэлтийг шуурхай шийдвэрлүүлэх арга хэмжээ авна. Хорооны ажиллах журмыг талууд хамтран батална.

26. Гэрээний хэрэгжилт, гэрээг дүгнэх

26.1 Гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлж, гэрээ, түүнтэй холбогдсон баримт бичгийг Талууд өөрийн цахим хуудсанд ажлын 3 хоногийн дотор байршуулна. Гэрээний хувийг ажлын 5 хоногийн дотор аймаг (сум, дүүрэг)-ийн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлд хүргүүлнэ.

26.2 Талууд гэрээний хэрэгжилтийг жил бүрийн 1-р сард багтаан Аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон Ажлын хэсэг дүгнэж, үнэлэлт дүгнэлт өгөх ба



гэрээний хэрэгжилтийн тайланг 2 дугаар сарын 1-ний дотор Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

26.3 Гэрээний хэрэгжилтийг заалт нэг бүрээр, тодорхой оноогоор дүгнэх бөгөөд тухайн жилдээ 60 буюу түүнээс доош оноогоор дүгнэгдсэн бол хангалтгүй гэж үзнэ. Гэрээний хэрэгжилт хангалтгүй дүгнэгдсэн бол Талууд хэрэгжилтийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг төлөвлөн, зохион байгуулна.

26.4 Талууд гэрээний хэрэгжилтийн тайланг дараа оны 2-р сарын 15-ны дотор геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

26.5 Гэрээнд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл талууд бичгээр хүсэлт гаргах бөгөөд уг асуудлаар Хамтын ажиллагааны хороо хуралдаж, харилцан тохирсноор өөрчлөлт оруулж болно.

27. Бусад

27.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

27.3 Гэрээг Монгол хэл дээр 3 хувь үйлдэж, хувийг талууд тус бүр хадгална.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ХОВД АЙМГИЙГ ТӨЛӨӨЛЖ:
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

М.АМАРСАНАА

МОЭНКО ХХК-Г ТӨЛӨӨЛЖ:
ДЭД ЗАХИРАЛ


Ж.ОЮУНЧИМЭГ

ДАРВИ СУМЫГ ТӨЛӨӨЛЖ:
ЗАСАГ ДАРГА

Б.ХАЙДАВ

ТОНХА ЭРХЭЛСЭН ЗАХИРАЛ

Х.ОТГОНБАЯР



M. F. R.